

ХУВЬЦАА ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газар (МУЗГ), Айвенхоу Майнз Монголия Инк ХХК (одоо Оюу Толгой ХХК гэх болсон) (ОТ ХХК), Айвенхоу Майнз Лимитед (Айвенхоу) болон Рио Тинто Интернэшнл Холдинг Лимитед (Рио Тинто)-ийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ (Хөрөнгө оруулалтын гэрээ)-тэй холбогдуулан МУЗГ болон Рио Тинтогийн хооронд байгуулж, 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр болов,

ОТ ХХК нь ОТ Төсөлтэй холбоотой Ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж, ОТ Төслийг хэрэгжүүлдэг;

Айвенхоу болон МУЗГ өөрсдийн зуун хувийн өмчит охин компаниудаараа дамжуулан ОТ ХХК-ийн нийт хувьцааны 66 хувь болон 34 хувийг тус тус эзэмшдэг;

МУЗГ болон Айвенхоу нь ОТ Төслийг удирдуулахаар Айвенхоугийн хамгийн том хувьцаа эзэмшигч болох Рио Тинтог сонгох эрмэлзэлтэй байгаа;

Рио Тинто нь тусгаар улс болон ОТ Төслийн түншийнх нь хувьд ОТ Төсөлтэй холбоотой МУЗГ-ын эрх, ашиг сонирхол болон ОТ ХХК, эсхүл ОТ ХХК-ийн хувьцааг шууд, эсхүл шууд бусаар эзэмшигч Айвенхоугийн бусад охин компанийн аливаа хувьцааг Бусдаас хараат этгээд эзэмших бодит нөхцөл байдал үүсэхтэй холбоотой МУЗГ-ын байр суурийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандахыг зөвшөөрч байгаа зэргийг харгалзан:

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан Талууд дараахь асуудлыг сайтар, үр өгөөжтэй байдлаар хэлэлцэн үзэж, ийнхүү хэлэлцсэнийгээ хангалттай байдлаар нотлохуйц нотлох баримтыг хүлээн авснаа зөвшөөрч дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1. Энэхүү Гэрээнд хэрэглэсэн том үсгээр эхэлсэн бүх нэр томъёо болон хэллэг нь тэдгээрийг хэрэглэсэн агуулгад өөр утга илэрхийлснээс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалтын гэрээн дэх утгатай адил утгыг илэрхийлнэ.

PROSCRIBED PERSON'S AGREEMENT

This Agreement is made between The Government of Mongolia (the “GoM”) and Rio Tinto International Holdings Limited (“Rio Tinto”) with effect from 8 June, 2011 in connection with the Investment Agreement dated October 6, 2009 (the “Investment Agreement”) between the GoM, Ivanhoe Mines Mongolia LLC (now known as Oyu Tolgoi LLC) (“OT LLC”), Ivanhoe Mines Ltd. (“Ivanhoe”) and Rio Tinto.

WHEREAS OT LLC is the owner of the Mining Licenses relating to, and is carrying out, the OT Project;

AND WHEREAS Ivanhoe and the GoM own, through their wholly owned subsidiaries, 66% and 34%, respectively, of the outstanding shares of OT LLC;

AND WHEREAS Rio Tinto is the largest shareholder of Ivanhoe and is intended by the GoM and Ivanhoe to be appointed to manage the OT Project;

AND WHEREAS Rio Tinto recognizes and respects the rights and interests of the GoM in the OT Project, both as a sovereign state and a partner in the OT Project, and its concerns relating to the potential holding by a Proscribed Person of any shares of OT LLC or another subsidiary of Ivanhoe that is a direct or indirect shareholder of OT LLC.

NOW, THEREFORE, for good and valuable consideration, the sufficiency and receipt whereof are hereby acknowledged, the undersigned hereby agree as follows:

1. All capitalized terms and expressions contained herein shall have the meanings ascribed thereto in the Investment Agreement unless the context otherwise requires.

2. Рио Тинто нь Айвенхоу, ОТ ХХК, эсхүл ОТ ХХК-ийн хувьцааг шууд, эсхүл шууд бусаар эзэмшигч Айвенхоугийн бусад охин компанид тухай бүр эзэмшиж буй аливаа хувьцаагаа МУЗГ-тай урьдчилан зөвшилцөхгүйгээр, түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Бусдаас хараат этгээдэд өөрөө шууд, эсхүл өөрийн Хамааралтай этгээд (Рио Тинто группын Хяналтанд байдаггүй Айвенхоу Группын гишүүдээс бусад)-ээр дамжуулан худалдах, эсхүл шилжүүлэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

3. МУЗГ нь ОТ ХХК-д тухай бүр эзэмшиж буй аливаа хувьцаагаа Рио Тинтотой урьдчилан зөвшилцөхгүйгээр, түүний зөвшөөрөлгүйгээр Бусдаас хараат этгээд (Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан түүний Хамааралтай этгээдийн аль нэгнээс бусад)-д өөрөө шууд, эсхүл өөрийн Хамааралтай этгээдээр дамжуулан худалдах, эсхүл шилжүүлэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

4. Хөрөнгө оруулалтын гэрээний 14 дүгээр Бүлэг (Маргаан шийдвэрлэх)-ийн заалтууд энэ Гэрээнд шаардлагатай өөрчлөлтүүдийн хамтаар үйлчилнэ.

5. Энэхүү Гэрээг Талууд заавал дагаж биелүүлэх бөгөөд Монгол Улсын хууль Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулж, тайлбарлана.

6. Энэхүү Гэрээ нь түүний зохицуулсан асуудлаар талуудын хооронд урьд байгуулсан бүх гэрээ, ойлголцлыг орлож үйлчилнэ.

7. Тал бүр энэхүү Гэрээг байгуулж хэрэгжүүлэх, түүнд заасан үүргийг биелүүлэх бүрэн эрх, хууль ёсны эрх мэдэлтэй гэдгээ бусад талууддаа баталж байна.

8. Энэхүү Гэрээг монгол, англи хэлээр тус бүр үйлдэх бөгөөд Тал тус бүр хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, англи хэл дээрх эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд хэрэв хоёр хэл дээрх эх бичвэрүүдийг тайлбарлахтай холбоотой эрх зүйн маргаан гарвал англи дээрх эх бичвэрийг баримталж байхаар Талууд харилцан тохиролцов.

2. Rio Tinto hereby agrees that it will not, and will cause its Affiliates (other than members of the Ivanhoe Group that are not Controlled by members of the Rio Tinto Group) to not, sell or transfer to a Proscribed Person any shares they may from time to time hold in Ivanhoe, OT LLC or another subsidiary of Ivanhoe that is a direct or indirect shareholder of OT LLC without prior consultation with and the written consent of the GoM.

3. The GoM hereby agrees that it will not, and will cause its Affiliates to not sell or transfer to a Proscribed Person (other than one if its Affiliates in accordance with the Shareholders' Agreement) any shares they may from time to time hold in OT LLC without prior consultation with and the approval of Rio Tinto.

4. The provisions of Chapter 14 (Dispute Resolution) of the Investment Agreement shall apply to this Agreement with necessary changes.

5. This Agreement is legally binding on the parties and shall be governed by and interpreted in accordance with the laws of Mongolia and international treaties to which Mongolia is a party.

6. This Agreement supersedes all previous agreements and understandings between the parties in relation to the matters regulated by this Agreement.

7. Each party warrants to the other parties that it has full power and lawful authority to execute and deliver this Agreement and to perform its obligations hereunder.

8. This Agreement will be provided and executed in the Mongolian and English languages, with each party retaining one copy of both documents in each language and the parties agree that the Mongolian and English versions will be treated equally except that, in the event of any legal dispute in the interpretation between the two-language versions, the English version shall prevail for both documents.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН, энэхүү Гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид Гэрээний эхэнд заасан өдөр гарын үсэг зурав.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж: Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д. Зоригт	Гарын үсэг: Огноо:
Сангийн сайд С.Баярцогт	Гарын үсэг: Огноо:
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх	Гарын үсэг: Огноо:

Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компанийг төлөөлж: Рио Тинто компанийн Зэсийн Группийн Ерөнхий захирал Эндрью Хардинг	Гарын үсэг: Огноо:
--	---------------------------------------

IN WITNESS WHEREOF this Agreement has been signed by the duly authorized representatives of the parties as of the date first written above.

For and on behalf of the Government of Mongolia: Minister of Mineral Resources and Energy D. Zorigt	Signature: Date:
 Minister of Finance S.Bayartsogt	Signature: Date:
 Minister of Nature, Environment and Tourism L.Gansukh	Signature: Date:

For and on behalf of Rio Tinto International Holdings Limited: Chief Executive of Rio Tinto Copper Andrew Harding	Signature: Date:
--	---------------------------------

